

СУХБААТАР АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024.06.25

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв сая төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Биелэлтийн хувь
---	--	----------------------------	------------------	---------------------	-----------------	--------------------	---------------------------------	--------------------

1. Бодлогын баримт бичигт тусгагдсан болон хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ

Газрын стратеги төлөвлөгөөний зорилго: Худалдан авах ажиллагааны тогтолцоонд мэдээллийн технологийн олголтыг нэвтрүүлж, ил тод нээлттэй, шилэн төндөрийг зохион байгуулна.

Зорилт 1.1 Худалдан авах ажиллагааг төлөвлөх, батлагдсан төсвийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашгтай байх зарчимд тулгуурлан зохион байгуулах, тайлагнах

Гүйцэтгэлийн зорилт								
1.1.1	Худалдан авах ажиллагааны газрын стратегийн төлөвлөгөөний 5.1.1 ТБОНӨХБАУХАТХ 44-р зүйл, 45-р зүйл МУ-ын Засгийн газрын зарим чиг үүргийг Сүхбаатар аймагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний 3.20. Сангийн сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 3.20, 3.21.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах тухайн жилийн төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулах						
		Тухайн оны төлөвлөгөөний биелэлтийн хувь	95%	97%	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/761 дүгээр захирамжаар анх баталсан. Тайлант хугацаанд 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/09 дүгээр захирамж, 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/183 дугаар захирамж, 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/295 дугаар захирамжаар тус тус шинэчлэн хуулийн хугацаанд батлуулсан. Төлөвлөгөөнд 55 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээний төндөр төлөвлөгөөнд тусгагдсанаас шууд худалдан авалтаар 13 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээ, бусад 42 нэр төрлийн бараа ажил үйлчилгээний төндөр зарлахаас 30 нэр төрлийн			80

						бараа ажил үйлчилгээний тендерийг зарлаж 14 нэр төрлийн 5,062,108,103 төгрөгийн бараа ажил үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан. Үнэлгээний шатанд 3 тендер, тендер хүлээж авах хугацаа болоогүй 11 тендер, гомдол гарч хянагдаж байгаа 1 тендер, шууд гэрээ байгуулсан 1 тендер тус тус байна. Үлдсэн 12 тендер нь холбогдох техникийн баримт бичиг боловсруулагдан батлагдах шатандаа хүлээгдэж байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 71.4 хувьтай байна.	
1.1.2	Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид зохион байгуулж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулах		Тухайн оны шилжсэн арга хэмжээний биелэлтийн хувь	100%	100%	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 15 нэр төрлийн 54,479,400,000 төгрөгийн бараа ажил үйлчилгээний тендер эрх шилжиж ирснээс 9 нэр төрлийн 44,890,921,005 төгрөгийн бараа ажил үйлчилгээний тендерийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна. Үнэлгээний шатанд 1 тендер, хүлээж авах хугацаа болоогүй 2 тендер, холбогдох техникийн баримт бичиг боловсруулагдан батлагдах шатандаа 3 тендер тус тус байна. Эрх шилжиж ирсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны	80

						төлөвлөгөөний биелэлт 80%-тай байна. Хэмнэлт 142,978,995 төгрөг үүсгэсэн байна.	
1.1.3	Олон улсын байгууллага, төслийн хөрөнгө оруулалтаар хийх худалдан авах ажиглалааг зохион байгуулах		Гүйцэтгэлийн хувь	100%	100%	"Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь" төслөөс 5 ажил эрх шилжиж ирснээс төндөрыг зарласан хүлээж авах хугацаа болоогүй 2, зураг төсөв хүлээгдэж буй 3 төндөр байна.	50
1.1.4	Худалдан авах ажиглалааг хууль тогтоомжийн хүрээнд ил тод, шуурхай, өрсөлдөх боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай, 100% цахим системээр зохион байгуулах, дүгнэж тайлагнах		Гүйцэтгэлийн хувь	96%	96%	Сүхбаатар аймгийн хэмжээнд зарлагдсан бүх төндөрийг Төрийн худалдан авах ажиглалааны www.tender.gov.mn цахим системээр 100 хувь зохион байгуулж, давхардсан тоогоор 79 төсөл, арга хэмжээний төндөр шалгаруулалтын зар, урилга, үр дүнг тухай бүр нийтэлсэн байна. Зарлагдсан бүх төндөр шалгаруулалтын үнэлгээг төндөрийн хүчинтэй байх хугацаанд хийж гүйцэтгэсэн байна.	100
1.1.5	Захиалагч болон төндөрт оролцогчид худалдан авах ажиглалааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх		Бүртгэл хөтөлсөн эсэх	-	1	2024 оны 1-2 дугаар сард 13 сумын худалдан авах ажиглалаа хариуцсан мэргэжилтнүүдтэй тайлан гаргах, төлөвлөгөө үүсгэх талаар болон хуулийн шинэчилсэн найруулгын талаар давхардсан тоогоор нийт 121 иргэн, хуулийн	80

							этгээдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. 2024.03-06-ны өдөр Аймгийн Засаг даргын Тамгын газарт, 2024-03-19-ний өдөр Баруун-Урт сумын ЗДТГ-ын албан хаагчдад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ танилцуулга, сургалтыг зохион байгуулж, нийт 53 иргэн хамрагдсан байна. Төндөрийн үнэлгээний хорооны гишүүнээр ажиллаж буй давхцсан тоогоор 241 гишүүнийг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажилласан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтыг 2024 оны 05 сарын 04-06 ны өдрүүдэд Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төв НУТББ-тай хамтран зохион байгуулсан. Тус сургалтад 51 хүн хамрагдаж, 33 иргэн буюу 65% нь шалгалтад тэнцэж, Худалдан авах ажиллагааны АЗ сертификат эзэмшсэн. Энэ оны хагас жилийн байдлаар 466 иргэнд сургалт,	
--	--	--	--	--	--	--	--	--

						мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.	
1.1.6		Тендер шалгаруулалтын урилга, үр дүн, гэрээг tender.gov.mn цахим сайтад байршуулж, мэдээллийн сан бүрдүүлэх, олон нийтэд ил тод мэдээлэх	Гүйцэтгэлийн үр дүнгийн хувиар	96%	98%	tender.gov.mn цахим сайтад тендер шалгаруулалтын урилга, үр дүнг давхцсан тоогоор 79 удаа, 23 гэрээг хугацаанд нь байршуулан мэдээллийн сан үүсгэн, олон нийтэд ил тод мэдээлэн ажиллалаа.	100
		Худалдан авах ажиллагаанд оролцогч төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх	Хамтран ажиллах гэрээ байгуулсан хуулийн этгээдийн тоо			2024 онд Сүхбаатарчууд бид ТББ, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо ТББ, Худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг 3 иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байна.	
1.1.7				-	3	Тус Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллүүд Аймгийн Засаг даргын захирамжаар одоогийн байдлаар худалдан авах ажиллагааны хөндлөнгийн гишүүнээр давхцсан тоогоор 50 төлөөлөл үнэлгээний хороонд орж ажилласан байна.	100
1.1.8	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2.4	Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлэх	Нийт худалдан авалтад дотоодын үйлдвэрлэлээс авсан бараа, бүтээгдэхүүний хувь	5%	5%	Манай газрын хувьд тендерийн баримт бичигт дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8-р зүйлд заасны дагуу тендерт оролцогчдод давуу эрх олгох тухай тусгаж давуу	80

							эрх тооцуулах", "Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 90 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт"-д орсон хэрэгцээт бараат дотоодын үйлдвэрээс авах, /барааны жагсаалтыг ирүүлэх" заалтыг тус тус оруулан зарладаг. 2024 оны эхний хагас жилийн байдлаар 4 төндөрт 1889.4 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн дотоодын үйлдвэрлэлээр худалдан авсан байна. Худалдан авалтыг зохион байгуулахдаа дотоодын үйлдвэрлэлийн худалдан нэмэгдүүлэхийн тулд төндөрийн нарийвчилсан үнэлгээнд тулхуу харгалзан үзэх тухай холбогдох албан хаагчдад зөвлөмж өгсөн.	
1.1.9	Сангийн сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 3.22	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний худалдан авах тухай хуульд заасан хугацаанд шийдвэр гаргах, шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдрийн хугацаанд худалдан авах ажиглалааны цахим системээр шийдвэр нийтлэхэд үнэлгээний хорооны		Цахим системд байршуулсан хурлын тэмдэглэлийн тоо	-	-	2024 оны эхний хагас жилийн байдлаар 23 төсөл арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, 49,953,029,108 төгрөгийн гэрээ байгуулсан ба төндөр шалгаруулалтын үр дүнг хуулийн хугацаанд худалдан авах ажиглалааны цахим системд байршуулж хэвшсэн. Одоогийн байдлаар төндөрт оролцогчоос хурлын тэмдэглэлтэй танилцах хүсэлт ирээгүй болно.	100

		хурлын тэмдэглэлийг хамтад нь байршуулж, хүсэлт гаргасан оролцогчид танилцуулах						
1.1.10	Сангийн сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 3.23	Худалдан ажиллагаа дахь захилагчийн эрх үүргийг хуулийн 48 дугаар зүйлд тодорхой тусгасан бөгөөд худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх		Цахим системд байршуулсан гэрээний тоо	-	-	2024 оны эхний хагас жилийн байдлаар 23 төсөл арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, захиалагчаас ирсэн бараа, ажил, үйлчилгээний гэрээг тухай бүр худалдан авах ажиллагааны цахим системд нийтлэн хэвшээд байна.	100
Хоёр. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ 2.1 Иргэн, Аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээ								
Төрийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас ирсэн санал хүсэлтийг хуулийн хүрээнд түргэн шуурхай шийдвэрлэх зорилтын хүрээнд								
2.1.1	Сангийн сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 3.25, Худалдан авах ажиллагааны газрын стратегийн төлөвлөгөөний 5.1.2	Байгууллагын мэдээллийн системийн аюулгүй байдал, хэвийн, тасралтгүй ажиглагааг хангах, хөгжүүлэх		Ажлын гүйцэтгэлээр	100%	100%	Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай компьютер, тоног төхөөрөмжийн гэмтэл, доголдыг засварлаж ажиллаж байна. Мөн шинээр зөөврийн хоёр компьютер худалдан авч тус бүрт оффисийн програм, вирусын програм суулгаж, дотоод сүлжээнд холбож, хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.	80
2.1.2		Мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх мэдээ, мэдээлэл, гарын		Арга хэмжээний тоо	-	5	Орон нутгийн телевиз болох BBS TV-ээр байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 3 удаагийн зар мэдээг нийтлүүлсэн. Мөн	

		авлага, шторк бэлтгэх, түгээх					төндөрийн урилгыг давхцсан тоогоор 79, олон нийтийг хамарсан арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажлуудын товч тайлан, мэдээ 6, постор, шторкийг 20 бэлтгэж нийт 108 удаагийн мэдээллийг “Сүхбаатар аймгийн Худалдан авах ажиллагааны газар” нэртэй пэйж хуудсанд байршуулж цахим сүлжээг ашиглан олон нийтэд тогтмол түгээж байна.	
		Худалдан авах ажиллагааны цахим систем болон байгууллагын цахим хуудсыг хэрэглэгч, захиалагч, нийлүүлэгчид сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах					Хэрэглэгч, захиалагчид болон байгууллагууд, иргэдэд Худалдан авах ажиллагааны цахим систем (https://www.tender.gov.mn/) - зэр хандан төндөрийн урилга, үр дүнт нийтэлж, түүнчлэн цахимаар төндөрт оролцох зөвлөгөө, заавар, төндөр зарлахтай холбоотой мэдээ мэдээлэл болон байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой болон цаг үеийн мэдээллийг байгууллагын цахим хаяг болох Сүхбаатар аймгийн Худалдан авах ажиллагааны газар нэртэй 540 гишүүнтэй фэйсбүүк групп бас 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр нээсэн Сүхбаатар аймгийн Худалдан авах ажиллагааны газар гэх 500 дагачтай фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан 1040 иргэнд мэдээллийг тогтмол хүргэж байна.	
2.1.3				Ажлын гүйцэтгэлээр	-	-		

2.1.4	Худалдан ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтыг цахим болон танхимын хэлбэрээр сургалт зохион байгуулах	Худалдан авах ажиллагааны		Хамрагдсан иргэдийн тоо	-	50	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтыг танхимаар 2024 оны 05 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төв НҮТББ, Сангийн яамтай хамтран зохион байгуулсан. Тус сургалтад 51 хүн хамрагдаж, 33 иргэн буюу 65% нь шалгалтад тэнцэж, Худалдан авах ажиллагааны АЗ сертификат эзэмшсэн.	100
2.1.5	Худалдан авах ажиллагааны газрын стратегийн төлөвлөгөөний 5.1.3	Хууль эрх зүй, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүний нөөцийн сургалтын төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах	2,5	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	-	90%	Хүний нөөцийн сургалтын төлөвлөгөөг боловсруухдаа албан хаагчдын санал хүсэлтийг хүлээн авч, тусган 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр газрын даргаар батлуулсан. Тус төлөвлөгөөнд 18 арга хэмжээ тусгагдсан бөгөөд хэрэгжсэн 8, хэрэгжих хугацаа болоогүй 10 арга хэмжээ байна. Төлөвлөгөөний биелэлт нь 80%-тай байна.	80
2.1.6	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай 12-р зүйл	Иргэн, төрийн болон бус байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хүрээнд цаг тухайд нь шуурхай шийдвэрлэж, тайлан мэдээг холбогдох байгууллагад хугацаанд нь тайлагнах.		Шийдвэрлэлтийн хувь	100%	100%	Худалдан авах ажиллагааны чиглэлээр Сангийн яаманд 4 гомдол гарч, төндөрийн шалгаруулалтын үнэлгээг дахин хийх шийдвэр 2, төндөр шалгаруулалтыг үргэлжлүүлэх шийдвэр 1 (захиалагчийн талд), шийдвэрлэх хугацаа болгоогүй 1 гомдол байна. Мөн өргөдөл, гомдлын тайланг улирал бүр аймгийн ЗДТГ-ын	100

	дагуу байгууллага дээрээ зохион байгуулж буй төндөрийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орж ажиллах, хамтран ажиллах					сургууль, Дорнод бүсийн Эрчим бүсийн Сүхбаатар аймаг дахь салбар ТӨХК-ийн ирүүлсэн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллуулах хүсэлтийг үндэслэн үнэлгээний хорооны гишүүнээр 4 мэргэжилтэн ХАА-г тухайн байгууллага дээр зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажилласан.	
--	---	--	--	--	--	--	--

Дөрөв. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт арга хэмжээ

4.1. Төсвийн шууд захирагчийн төсвийн хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийг хөтлөн, төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайланг тайлагнах							
4.1.1	Төсвийн тухай хуулийн 41.1, 41.2, 47.1, 8.9.1	Батлагдсан төсөв, нэмэлт төсвийн санхүүжилтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, байгууллагын санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээ гаргаж, албан хаагчдын цалин хөлс, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог цаг тухай бүрд нь хийж, тайлан гаргаж, баталгаажуулах.	Тайлан хугацаанд нь хүргүүлсэн эсэх	-	1	Манай байгууллагад нийт 348,269,490 төгрөгийн төсөв батлагдснаас эхний хатас жилийн байдлаар 178,420,200 төгрөгийн санхүүжилттэй байна. Үүнээс 112,751,220 төгрөгийн гүйцэтгэл гарсан. Үүнд: Цалингийн зардалд 88,396,550 төгрөг -Нийгмийн даатгалын зардалд 10,146,904 төгрөгийг зарцуулж, холбогдох тайлан мэдээг хуулийн хугацаанд нь сар бүр илгээсэн байна.	100
4.2 Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, дотоод журмыг мөрдөх, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хөдөлгөөнийг бүртгэж, тайлагнах, удирдлага, байгууллагууд, хэрэглэгчийг шаардлагатай мэдээллээр хангах							
4.2.1	Төсвийн тухай хуулийн 16.5-р зүйл	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай эд хөрөнгө бараа материал бэлтгэх, урсгал засвар хийх.	Ажлын гүйцэтгэлийн хувь	100%	100%	Тус байгууллага нь эхний хатас жилийн байдлаар 4,180,000 төгрөгийн тоног төхөөрөмж, 1,650,000 төгрөгийн санхүүгийн программ хангамж, 1,146,800 төгрөгийн бичиг хэрэг, 1,347,216 төгрөгийн аж	100

	албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах хөрөнгийг төсвийн хүрээнд зарцуулах					ахуйн материал, 2,200,000 төгрөгийн шатахуун зэрэг байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай зардалд зарцуулсан байна. Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу Эх үрсийн баярыг тохиолдуулан “Жаргалтай үрс” арга хэмжээг Эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулсан. Үүнд: албан хаагчийн хүүхэд бүрт баярын бэлэг, байгууллагын 2 албан хаагчийн 80-аас дээш настай 2 эхэд хүндэтгэл үзүүлж, нийт 1,905,000 төгрөгийг зарцуулсан байна. Мөн албан томилолтыг 3 албан хаагчдад 1,035,000 төгрөгийг, сургалтын зардалд 560,000 төгрөгийг тус тус зарцуулсан.	
4.2.2	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 61.1	Эд хөрөнгийн дотоод тооллогыг жилд 2 удаа зохион байгуулж, тайлан, үр дүнг гаргаж, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлд саналыг хүргүүлэх	Зөвлөмж, саналын тоо	-	2	Аймгийн ИТХ-ын 2024 оны 06 сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын дагуу Орон нутгийн өмчийн газраас шилжиж ирсэн 42,698,661 төгрөгийн үндсэн хөрөнгийг байгууллагын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/06 дугаар тушаалаар байгуулагдсан Өмч хамгаалах байнгын зөвлөлтэй хамтран тооллого хийж, үндсэн хөрөнгийг хүлээн авч, данс бүртгэлд тусган албан хаагчдын хөрөнгийг картжуулж, эд хөрөнгө, ашиглалт хариуцлагын гэрээг байгуулж ажиллаж байна.	100

4.3 Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах, үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлэх						
4.3.1	Төрийн албаны тухай хуулийн 54, 55-р зүйл, 3Г-ын 2020 оны 217 дугаар тогтоол, 3Г-ын 2023 оны 301 болон 442 дугаар тогтоол,	Байгууллагын болон албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтийг www.sukhbaatar.igovernment.gov.mn цахим системээр төлөвлөж, тайлагнах, баталгаажуулах		Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь	-	90%
				Зөвлөмжийн тоо, Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний нийлбэр хувь,		
				Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 16 тоот албан бичгээр Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн. Аймгийн Засаг дарга бөгөөд төсвийн Ерөнхийлөн захирагчтай 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулсан. Тус оны төлөвлөгөөнд 4 зорилт 29 арга хэмжээ тусгагдсан. Тус төлөвлөгөөг www.sukhbaatar.igovernment.gov.mn сайтад байршуулсан. Эхний хагас жилийн байдлаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт нь 91,5%-тай байна. Сүхбаатар аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан хариуцсан ХХК-ийн хариуцсан мэргэжилтэнтэй холбогдож байгууллагын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг байршуулах боломжтой эсэхийг судалсан боловч аймгийн удирдлагуудтай зөвшилцөж байгаа талаар хариу өгсөн тул одоогийн байдлаар албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө ороогүй байна.		

4.3.2	Төрийн албаны тухай хуулийн 27-р зүйл, 29-р зүйл, 31, 32-р зүйл 55-р зүйл, 61 дүгээр зүйл	Төрийн хаагчийн албан сургалт, ажиглах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, батлуулах	Төрийн албан хаагчийн сургалт, ажиглах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр болон хүний нөөцийн стратеги төлөвлөгөө батлуулсан эсэх	-	1	Төрийн албан хаагчийн сургалт, ажиглах нөхцөл, нийгмийн баталгааны (2024-2027) хөтөлбөрийг газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар батлуулсан. Тус хөтөлбөрийг 2 жилд 1 удаа үнэлэх, үр дүнг тооцохоор тусгасан. Мөн Газрын даргын 2024 оны А/12 дугаар тушаалаар "Хүний нөөцийн стратеги төлөвлөгөө (2024-2027)-г батлуулсан. Тус төлөвлөгөөнд 5 чиглэлээр 25 арга хэмжээг тусгаж хэрэгжүүлж байна.	100
4.3.3	Төрийн албаны тухай хуулийн 12,1, 14.1,	Газрын хэмжээнд хөтлөгдөх баримт бичиг, гадны байгууллагатай гэрээ, байгуулах дотооддоо дагаж мөрдөх дүрэм, журмууд холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавих, албан хаагчдын боловсруулж буй тушаалын төсөл, албан бичгийн хууль зүйн үндэслэлийг хянах, зөвлөх	Хянасан дүрэм, журмын тоо	-	2	"Худалдан авах ажиллагааны газрын дүрэм"-ийг боловсруулж, Аймгийн Засаг даргын 2023 оны А/664 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралтаар батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг батлуулсан. Хөлсөөр ажиллах гэрээг 3 иргэн, байгууллагатай, хамтран ажиллах гэрээг 1 аж ахуйн нэгж байгууллагатай байгуулан ажиллаж байна. Байгууллагын хэмжээнд хөтлөгдөж буй А, Б тушаалын төсөлд захиргааны акт (тушаал)-ын хяналтын дагалдах хуудсыг ашиглаж,	100
			Зөвлөмжийн тоо	-	2		

							мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр ханган ажиллаж байна.	
4.4 Архив, албан хэрэг хөтлөлтийн хэвийн үйл ажиллагааг хангах								
4.4.1	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 34.1, 35.1, ТБОНӨХБАУХАТХ-ийн 48.5	Ирсэн бичгийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж, шийдвэрлэлтэд хяналт тавих, явуулсан бичгийг хянаж, баталгаажуулан цаасаар болон цахимаар илгээх		Ажлын гүйцэтгэлээр	-	100%	Эхний хагас жилийн байдлаар байгууллагаас харилцагч байгууллагуудад нийт 133 албан бичгийг кригл болон үндэсний монгол бичгээр хамтатган явуулсан. Үүнд -Эх хувиар 66, -цахим хэлбэрээр 67 Харилцагч байгууллагуудаас нийт 75 албан тоот бичиг ирсэн. Үүнд -цахимаар 38, эх хувиар 37. -Хариутай бичиг цахимаар 11 - хариутай бичиг эх хувиар 8 - хугацаандаа явсан 10 -Хугацаа хэтэрсэн 1 -Хугацаа нь болоогүй 8 албан бичиг тус тус байна.	90
4.4.2		Баримт бичгийн нягтлан шалгах комиссын үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу явуулах, хэтлэх хэргийн нэрийн жагсаалтыг хэлэлцэн батлуулах		Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт баталсан эсэх	-	1	Газрын даргын 2024 оны А/09 дүгээр тушаалаар "Байгууллагын баримт нягтлан шалгах комисс"-ийг байгуулсан. Худалдан авах ажиллагааны газрын 2024 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр БНЦЛК-ийн хурлаар хэлэлцэж, газрын даргаар батлуулсан. Тус хөтлөх хэргийн жагсаалтад хөтлөгдсөн хэргээс 37, Үүнээс: байнга хадгалах хадгаламжийн нэгжийн тоо 16,	100

						70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн тоо 6, түр хадгалах хадгаламжийн нэгжийн тоо 15 байна.	
	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэх, архивын баримтын бүртгэлийн дагуу архивын баримтаас лавлагаа олгох, баримтын хадгалалт, хамгаалалтыг хариуцах, тайлан мэдээ гаргах, архивт баримт хүлээн авах, хадгалах нөхцөл бүрдүүлэх		Хадгаламжийн нэгжийн тоо, лавлагаа олгосон бүртгэл	-	-	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу төндөрийн баримт болох 5 баримтыг архивын нэгж үүсгэн архивласан. Манай байгууллагад АТГ-аас хяналт шалгалт ирж 2020-2024 оны төндөрийн баримтуудыг хуулбар үнэн дараасаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Аймгийн Засаг даргын 2023 оны А/664 дүгээр захирамжийн дагуу Худалдан авах ажиллагааны газар шинээр байгуулагдаж, одоогоор өрөө тасалгаа дутмаг байгаа учир архивын өрөө болон баримт хадгалах шүүгээгүй байна.	100


4.5. Байгууллагын дотоод хяналт, ил тод байдлыг хангах

4.5.1	Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд түгээх, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах		Вэб сайттай эсэх	-	1	Байгууллагын домэйн хаягийг нээлгэж, вэб сайт хийлгэх байгууллага, хувь хүний санал болгож буй үнийн саналын судалгааг хийж, өөрсдөө хариуцан хийх талаар судалж байна.	80
	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 8.8, 8.12	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах	Хамтарч ажилласан байгууллагын тоо	-	2	Манай байгууллага нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болох орон нутгийн BBS TV, Сүхбаатарын Өнгө сонин, Зууны мэдээ сонинтой хамтран ажиллаж байна. BBS TV-д үндсэн үйл ажиллагаатай	
4.5.2			Мэдээлэл байршуулсан тоо	-	30		

						холбоотой 3 удаагийн зарыг олон нийтэд түгээсэн байна. Байгууллагын "Худалдан авах ажиллагааны газар" пэйж хуудсанд өдөр бүр тогтмол байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, төндөрийн урилга, бусад мэдээллийг тогтмол байршуулсан. Tender.gov.mn сайтад төндөрийн урилгыг давхцсан тоогоор 79 удаа байршуулаад байна.	
			Төлөвлөгөөний биелэлтийн хувь	-	85	Газрын даргын 2024 оны А/13 дугаар тушаалаар "Дотоод хяналт-шалгалтын нэгж"-ийг байгуулсан. Дотоод хяналт, шалгалтын нэгжийн 2024 оны ажлын төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр газрын даргаар батлуулсан. Тус төлөвлөгөөний дагуу 7 зорилт бүхий 13 арга хэмжээ төлөвлөсөн. Байгууллагын дотоод хяналт, шалгалтыг хийхэд дараах 3 зөрчил илэрсэн. Үүнд 1.Шилэн данс- хугацаа хоцорсон мэдээлэл 1 2.Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу. 3.Архивын хадгалалт, хамгаалалт, Архивын өрөөгүй, стандартын шаардлага хангасан шүүгээ байхгүй, эмх цэгцгүй, хадгаламжийн нэгжийн бүртгэл байхгүй байна.	100
4.5.3	Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах, хяналт тавих	Арилгасан зөрчлийн тоо	-	-		
			Дүгнэлт зөвлөмжийн тоо	-	2		

						Дээрх зөрчлийг газрын даргад танилцуулж, холбогдох албан хаагчдад зөвлөмж өгч зөрчлийн арилгуулан ажигласан.	
4.5.4	Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол	Тэрбум үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, ажил гүйцэтгэх гэрээ байгуулах	Гэрээ байгуулсан байгууллагын тоо	Модны ургалтын хувь	-	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2024 оны 05 дугаар сард хаврын тарилтаар Баруун-Урт сумын 1-р багт орших Сүхбаатар-Соёл амралтын хүрээлэнд байршилтай өөрийн хуваарьт газарт 70 ш хайлаас модыг шинээр тарисан. Мөн усаалгаа арчилгааг өөрсдөө болон мэргэжлийн байгууллага болох Сүхбаатар-Соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-тай хамтран ажиллах гэрээг байгуулж усаалгааг 1 сард 4 удаа хийлгэн хамтран ажиглаж байна. Усаалгааны зардалд сар бүр 50 литр түлш олгож байна.	100
НИЙТ ХУВЬ							
91.5%							

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ХЯНАСАН:

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН  Ө.ТАЙВАНСАНАА

АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ДОТООД АЖИЛ,

ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



TV34134 17234010005 3626984

2024.06.24

2024.06.24